

УЛАМЖЛАЛТ АНАГААХ

“Хамба Шивацо”-ын намтар, зохиол бүтээл, “Дарь эхийн буман ногоо” зохиолын онцлог

Анхцацрал Л., Наранзаяа Л., Сайжрах Б., Буянт Б.

*Өвөр монголын үндэстний их сургууль
e-mail: lankhtsatsral@gmail.com*

Abstract

Biography and writing of Hambo Shivatso, and features of “Hundred thousand herbs of Tara”

Ankhtsatsral.L, Naranzaya.L, Sajjirakhu B., Baoyintu B.

*Inner Mongolian University of Nationalities
e-mail: lankhtsatsral@gmail.com*

Introduction

It is important to study old medical books written by the afore time doctors and deeply realize scientific based concepts in these books and understand the reference and deep meaning medical secret of the traditional doctors which are the basis of the traditional medical development of 21st century. The main research direction to address this issue is to study and develop traditional medicines.

Goal

The goal of the research is to study Biography and writing of Hambo Shivatso, and features of “Hundred thousand herbs of Tara”.

Objectives:

1. To clarify biography of Khambo Shiva Tso
2. To clarify contribution and scripts of Khambo Shiva Tso to Medicine.
3. To identify some of advantages and individuality of “The hundred thousand herbs of Tara”.

Materials and Methods

We conducted the study by using original manuscript analysis, biographical research method, checklist method and analysis and synthesis method. We have used following materials as main resource: “The hundred thousand herbs of Tara” which is “*ཐོག་མཐུན་མཚན་ལུགས་*” written by Khambo Shiva Tso in Tibetan-Chinese publishing was used as a main material and “The Wonderful Illumination To The Understanding Of Knowledge” by Jambaldorj, “Crystal rosary” by Danzanpuntsag, “White Crystal Dictionary Of Medicie” by Sumbe Khambo Ishbaljir and “Blue Annals” by Shonnupel Goy-Lotsava were used as an auxiliary material in current study. Furthermore, we used “Tibetan-Mongolian Medical dictionary” by Galsan.S and “Tibetan-Mongolian complex dictionary” for translating study materials from Tibetan.

We took a permission to conduct the current study from the National University of Inner Mongolia and the study subject and methods were confirmed. Due to the study was conducted by historical source method, in each and every citation we took from scripts, we put the author’s name to not infringe any copyright.

Result

1. The Khanchen Shiva Tso was born as a prince in 725 of Common era in Sakhor which is now Rewalsar at Himachal Pradesh, India. He spent his youth to study in Nalandra monastery. Furthermore, he was invited to Tibet by invitation of Tisron Devzan king in 767. He contributed to translate The Great Tibetan Buddhist sutra (Ganjur), main scripts of buddhism, Major and Minor ten scripts from Hindu to Tibetan.
2. His creatures and scripts have become the fundament of all yoga types and meditation nowadays. In other words, his scripts made the beginning of non-drug therapy. And from “Hundred thousand herbs of Tara” we can know the Khambo Shiva Tso was owned great knowlegde regarding buddhist major and minor ten wisdoms, in particular pharmacology and nutrition
3. In “Hundred thousand herbs of Tara” script outer features, taste, medicinal usage of more than 200 herbs as well as the appropriate time of collecting and preparing these herbs were written comprehensively. Furthermore much more detailed explanations were written in this script and it is assumed that Mongolian scientist used these scripts for their creatures and books.

Conclusion

The Khambo Shiva Tso is popular scientist in Tibet and he wrote number of scripts and books regarding middle path, meditation and contributed to translate scripts from Sanskrit to Tibetan. The main creature he wrote by his own and made him to connect Medicine is the reference book “Hundred thousand herbs of Tara” which was about medicinal raw materials of herb, this is the most ancient reference book of pharmacology translated from Sanskrit to Tibetan.

Key words: tara, Tystrondesone king, middle path, khambo, herbal medicine

Pp. 68-73, Table 1, References 20

Үндэслэл

Энэтхэгт албан ёсны зохион байгуулалт бүхий шашинбайжбайгаад эдүгээ үгүй болсон Буддизм тус оронд арван долоон зууныг (МЭӨ V зуун – МЭ XII зуун) хамарсан түүхтэй болой. Тавдугаар зуунаас хойш энэтхэгийн сүм хийдүүд судалгаа шинжилгээ хийн эрдмийн зэрэг горилох төвүүд болж хөгжиж байсны тэргүүлэгч нь Наланда хийд болж байжээ[1]. Чухам энэ газарт эрдмийн гараагаа эхэлж номд боловсроод төвөдөд уригдан очиж бурхны шашныг дэлгэрүүлэхэд маш том хувь нэмэр оруулсан [2-3] гэх Хамба Шивацогийн ургамалын эмийн лавлах болсон бүтээл [4] санскрит хэлнээс төвөд, төвөд хэлнээс хятад хэлэнд орчуулагдсан байсныг олж үзээд уг эрдэмтэн буддын шашны төв үзлийн номлолоос өөрөөр анагаах ухаанд ямар хувь нэмэр оруулсан, ямар зохиол бүтээл туурвисан бөгөөд “Дарь эмийн буман ногоо” гэх уг бүтээл бусад эмийн номнуудаас ямар давуу талтай болохыг судалж тогтоох нь зүйтэй гэж үзсэн билээ.

Зорилго

Хамба Шивацогийн намтар, зохиол бүтээл, “Дарь эхийн буман ногоо” зохиолын онцлогийг тодруулах

Зорилт:

1. Хамба Шивацогийн намтрыг тодруулах
2. Хамба Шивацогийн бүтээлүүд, анагаах ухаанд оруулсан хувь нэмрийг тодруулах
3. “Дарь эхийн буман ногоо” бүтээлийг төвөд хэлнээс монгол хэлэнд орчуулж бусад эмийн зохиолуудаас ялгагдах онцлог, давуу талыг тодруулах

Материал, арга зүй

Бид энэхүү судалгаандаа эх бичиг сурвалж бичиг судлалын арга, түүхэн хүн судлалын арга, магадлан жагсаах арга, анализ синтезийн аргуудыг [5] ашигласан бөгөөд судалгааны гол материалд Хамба Шивацогийн “ཤྷལ་མ་ཕྱོགས་ལྷན་པོ་” [4] монголоор “Дарь эхийн буман ногоо” бүтээлийн төвөд-хятад хэл дээрх хэвлэлийг ашигласан. Туслах материалд Жамбалдорж “Үзэсгэлэнт нүдэн чимэг” [6], Данзанпунцаг “Эмийн хир үгүй болор эрхи” [7], Сүмбэ хамба Ишбалжирын “Цагаан болор толь”[8], Шоннупэл Гойлоцава “Синья летопись” [2], судалгааны гол материалаа төвөд хэлнээс орчуулахад Галсан С. “Төвөд монгол эмнэлгийн толь” [9], Тэрбиш Л. “Төвөд монгол иж бүрэн толь” [10] бүтээлүүдийг ашиглалаа.

2019 оны 12дугаар сарын 4нд Өвөр монголын үндэстний их сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар судалгааны ажлын сэдэв, аргачлалыг батлуулан судалгаа хийх зөвшөөрлөө авсан бөгөөд уг судалгаа нь сурвалж бичгийн судалгаа учир ном, бүтээлийн зохиогчийн нэрийг ишлэл авсан тухай бүртээ дурдан зохиогчийн эрхийн ямар нэг зөрчил үүсгэхгүй байхад анхаарсан болно.

Үр дүн

1. Бид зохиогчийн төрсөн болон амьдарч байсан цаг хугацаагаар хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлэн түүхийн судалгааг хийж зохиогчийн намтрыг судлав. Түүнийг Их Ханба, Үнэнхүү үзүүлэн зохиогч, Шантаракшида, (Sanskrit: Śāntarākṣita; Tibetan: ཞི་བའ་མཚོ།, Wylie: zhi ba tsho), Их хамба Бодьсад, Бодьсад, хэмээх бөгөөд төвөдүүд түүнийг Ханчэн Шивацо хэмээн дууддаг. Түүний намтрыг бичсэн эх сурвалжууд дээр төрсөн оныг 725 болон 729 гэж өөр өөр бичсэн байсныг тодруулж үзсэн бөгөөд “Дарь эхийн буман ногоо” зохиолын арын хэсгийн тайлбар эхээс хөхөгчин тахиа жилд төрсөн гэснийг үндэслэн он тооллыг хөөвөл Ханчэн Шивацо бээр нийтийн тооллын 725 онд Сахор улс /одоогийн Бүгд найрамдах энэтхэг улс/-ын Химачал мужид Рэвалсар / Rewalsar, Himachal Pradesh, India/ хэмээх газар хааны хүү болон мэндэлжээ. Түүнийг 767 онд Төвөдийн Тисрон Дэзон хааны урилгаар Төвд рүү залжээ. Тухайн үед Төвд рүү нэвтрэхийн тулд одоогийн непал улсаар дамждаг байсан бөгөөд тэр үед дайн болсоны улмаас Непалд зургаан жилийг өнгөрүүлсний эцэст Төвөдөд морилсон. Тэрээр Төвдийн хамгийн анхны хийд болох Самъяа хийдийг гүрү Ловон бадамжунай тэргүүтэн дээдэстэй хамтран байгуулсан бөгөөд . Ловон Бадамжунай, номын хаан Тисрондэзон, энэ бодисадва нь хамба, ловон номын хаан гурав гэж алдаршсан. Анхны долоон Төвөд хүнд сахил хүртээж байсан ба Энэтхэгийн Ловон вимала мадри, Ловон Санжай санва тэргүүтэн их мэргэдийг урин авчирч бурханы иш зарлиг, анагаах ухаан, зурхайн ухаан зэрэг шашдирыг Төвд хэлэнд орчуулж Төвд оронд бурхны шашин дэлгэрэх суурийг тавьсан билээ. Тэрээр Төвд оронд шашин дэлгэрүүлэх үйлсийг зохиосоор нийтийн тооллын 788 онд номын агаарт

шингэн нирваан дүрийг үзүүлжээ.

2. Тэрээр анагаах ухаан, дотоод ухаан, урлахуйн ухаан зэрэг их бага арван ухаанд мэргэжсэн бөгөөд төвөдөд бурхны шашин дэлгэрэхэд асар их үүрэг гүйцэтгэсэн билээ. Энэтхэг хэлнээс Төвд хэлэнд ганжур болон бурхны шашны гол зохиолууд хийгээд их бага арван ухааны номуудыг орчуулахад голчлон оролцсон байдаг. Тэрээр буддын гүн ухаан, шашинд хобогдох “Хорин товчийн тайлбар”, “Шивацогийн үлгэр, хоосон чанарын хураангуй”, “Маргалдах ухааны тайлбар ба утгын маш ялгахуй”, “Үнэхээр дарагч очир хэмээх зарлигийг номлов”, “Ялж төгс нөгчсөн цог өлзийт Очирваанийн агуу их эгшигийг номлов”, “Түүнчлэн ирсэн наймын магтаал” гэх мэт бүтээлүүд туурвисан байна. “Төв үзлийн чимэг”, “Хоёр үнэний маш ялгахуйн бэрх тайлбар”, “Амьдруулан амирлуулах чимэгийн тайлбар” бясалгал, иогийн чиглэлийн сургаал номууд нь тэр үедээ шашны чиглэлээр, гүн ухааны бүтээл болж байсан ба Америкийн Стенфордын сургуулийн гүн ухааны салбараас түүний бүтээлүүдийг орчуулан хэвлүүлж, хүмүүст ойгомжтой болгон тайлбарлаж эхэлснээр одоогийн эрүүл амьдах ухааны чиглэлээр дэлгэрээд байгаа бүх төрлийн иог, бясалгалуудын суурь болж анагаах ухаанд ухаанд эмгүй эмчилгээний эхлэлийг тавьжээ. “Дарь эхийн буман ногоо” хэмээх ургамалын гаралтай дан эмүүдийн тухай дэлгэрэнгүй бичсэн бүтээлд нийт 200 гаран ургамалын гаралтай эмт бодисыг гадаад бүтцээс нь эхлээд амт, чадал, голдуу засах, түүх цаг зэргийг дэлгэрэнгүй бичсэн байгаа нь Хамба Шивацо нь буддын шашны их бага арван эрдэмд тэр дундаа тэжээхуйн ухаан, эм судлалын өндөр мэдлэгтэй байсныг харуулж байгаа ба МЭ VIII зууны үед бичигдсэн учраас одоогоор бидэнд олдоод байгаа “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн ийн дараа орох, санскрит хэлнээс төвөд хэлэнд орчуулагдсан, хамгийн эртний эмийн зохиол, гарын авалга болж дараа дараагийн бүтээлүүд туурвигдахад лавлах бичиг болсон байх магадлалтай байна.
3. Бид “Дарь эхийн буман ногоо” бүтээлийн онцлог, давуу талыг гаргахын тулд орчин үеийн сургалт, судалгаанд их ашиглашддаг бусад эмийн бүтээлүүдтэй харьцуулан үзлээ.

Table 1. Comparison of the features of “The hundred thousand herbs of Tara” with other medicinal writings

№	Writer	Book title	Date of writing	Content
1.	Not clear	Four Medical Tantras Of Medical Science	7th century	The quality and potency of more than 100 drugs of animal, plant and mineral origin are mentioned. The herbal single drugs were divided into 8 parts and some of them were described in detail.
2.	Khambo Shiva Tso	Hundred Thousand Herbs Of Tara	8th century	Listed more than 230 herbal medicines by detail, including names, types, uses, history of some drugs, place of origin, quality, potency, and method of administration.
3.	Jambaldorj	The Wonderful Illumination To The Understanding Of Knowledge	1817-1823	Included total of 610 single medicines of animal, mineral and plant origin with 576 illustrations, Mongolian, Tibetan, Chinese, Manchu names and detailed descriptions.
4.	Sumbe Khambo Ishbaljir	White Crystal Dictionary Of Medicine	1752-1785	801 species of drugs are divided into 7 parts, along with Tibetan and Sanskrit names, indicating the place of growth, shape and taste.
5.	Tsahar Gebsh Luvsanchultem	Identifiable Knowledge Of Medicine	1770-1785	Described 478 species of drugs with methods of identification, names and detailed descriptions.
6.	Danzanpuntsag	Crystal rosary	1840-1845	Summarized and commented drugs of The “Moon King of drugs and external therapies ” and “Four Medical Tantras Of Medical Science”

Эндээс харахад монгол эрдэмтдийн бүтээлүүд 18 дугаар зуунаас эхлэн бичигдсэн байхад “Дарь эхийн буман ногоо” бүтээл “Анагаах ухааны дөрвөн үндэс”-тэй ойролцоо хугацаанд бичигдсэн бөгөөд маш нарийн тайлбар, тайлал багтаасан байгаа нь энэ зохиолоос монгол эрдэмтэд суралцаж, зохиол бүтээлдээ ашигласан байх талтай байж болохыг харуулж байгаа юм.

Хэлцэмж

А Буддын шашны гэгээнтэн, гүн ухаантнууд анагаах ухаантай холбогдох нь:

Философич, профессор Хархгуай <<“Харьцангуй онол”-оороо алдаршсан, дэлхий дахинд бурхан лугаа адил шүтэн бишрэгдсэн суут эрдэмтэн Эйнштейн “Бүх шашны дотроос шинжлэх ухааны гэгдэх цорын ганц шашин бол буддизм” хэмээсэн нь тэрээр дорно дахины их бага 10 ухаан, шинжлэх ухааны гүн гүнзгий утга агуулгыг үнэлэн хэлсэн байдаг>> [11] гэж дурдсанаас харахад анагаах ухаан нь тэжээхүйн ухаан нэрээр буддын их таван ухааны нэгт багтсан

байдаг ба буддын шашны их бага 10 ухааныг эзэмшсэн гэгээнтнүүд анагаах ухааны талаар мэдлэгтэй байж, анагаах ухааны чиглэлийн зохиол бүтээл туурвиж чаддаг, анагаах ухаан нь буддын шашинтай зарим нэг талаараа салшгүй холбоотой байдаг байж болох юм. Сукумар Дасс “Буддхын шашны түүх” номдоо <<Эртний буддын шашны сургалт нь маш нарийн дэг журмаар, өндөр чанартай явагддаг байсан байна>> [12], Буддын соёл судалгааны төв өөс эрхлэн гаргасан “Буддын шашны соёлын тайлбар толь”-д <<Аливаа шашин нь шашны ертөнцийг үзэх үзэл, шашны сэтгэлзүй, шашны зан үйл гэсэн өөр хоорондоо шүтэлцсэн 3 хэсгээс бүтэх ба буддизмд ертөнцийг үзэх үзэл сургаал, ухааныг нь голлодог “Их хөлгөний ёс”, зан үйл, сэтгэлзүйг голлодог “Бага хөлгөний ёс” хэмээх чиглэлүүд байдаг>> [13] гэсэнээс үзвэл буддын гүн ухаанд суралцагсад сэтгэлзүйн сургаал номлол сонсож сурахаас гадна зан үйл буюу практик ажиллагаанд мөн суралцаж байсан ба үүнд нь анагаах ухааны оношилгоо, эмчилгээ ч багтдаг байсан нь дамжиггүй. Академич Ш. Болдын

“Гүн ухаан, онол, биемахбод судлал” [14] болон “Монголын анагаах ухааны түүх” [15], Буянт Б., Зууннаст Ж. Нарын “Монгол анагаах ухааны мэргэдийн намтар бүтээлийн судлал” [16] гэсэн бүтээлүүдээс харахад Монголын анагаах ухааны нэрт эрдэмтэн мааранбууд буддын шашны их бага таван ухаанаар мэргэшсэн, анагаах ухааны бүтээлүүдээс гадна гүн ухаан, бусад чиглэлийн бүтээл туурвисан байдаг нь 20-р зуунд монгол улсад өрнийн анагаах ухаан орж ирэхээс өмнө анагаах ухааны сургалтууд сүм хийдүүдийг түшиглэн явдаг байсантай холбоотой юм гэсэн ойлголтонд хүрч болох юм.

Б. Санскрит, төвөд хэл дээрх бүтээлүүдийг монгол хэлээр орчуулах шаардлага.

Академич Ш. Болд “Төвөд хэл сурах бичиг” номдоо <<Монгол анагаах ухааны хөгжлийн оргил үе нь Энэтхэгийн “Аюурвед”, Төвөд анагаах ухааны ном судрын уламжлалтай нягт холбоотой учир, нөгөө талаар монгол мэргэдийн анагаах ухааны талаар бичсэн номын доторх онол, практикийн мэдлэгийг алдаа мадаггүй ухааръя гэвэл төвөд хэл чухал ач холбогдолтой>> [17], мөн “Монголын Анагаах Ухааны Түүх. 4-р боть”-доо <<Монгол анагаах ухааны хөгжил эхэн үедээ Энэтхэгийн “Аюурвэд”-ийн анагаах ухаантай, дунд, үеийн сүүл хэсгээсээ хойш Төвөдийн анагаах ухааны түүхтэй нарийн шижмээр холбоотой хөгжиж иржээ. Иймээс монголын уламжлалт анагаах ухааны түүхийн хүрээнд Төвөдийн анагаах ухааны түүхэн зохиолуудыг багтаан авч үзэхгүйгээр судлах бололцоогүй юм [18]. Ш. Бира <<Эртний энэтхэгчүүдийн хэл болох санскрит хэл төвөд хэлний хамтаар монголд шашин номын их хүндтэй хэл байсан бөгөөд санскрит хэлийг бурхны хэл, ариун номын хэл гэж үздэг байв>> [19] гэж тус тус бичсэн нь санскрит, төвөд хэлнээс судар ном орчуулан шинжлэх ухааны судалгаанд ашиглах нь ач холбогдол өндөртэйг харуулж байна.

Мөн Академич Ш. Болд << “Жаргалын эзэн их Ютог Ёндонгомбын үлэмжийн аврал, нууц тэмдэгт зарлиг сүр жавхлант их эрдэнийн хөмрөг”-т Төвөдийн 38-р хаан Тисрондэзан “надаас өмнө өвөг дээдэс анагаах ухааны тогтолцоог бий болгосон. Одоо надад төвөд хэлрүү орчуулаагүй анагаах ухааны олон ном байна. Төвөдийн анагаах ухааныг хөгжүүлэхийн тулд эдгээрийг орчуулах хэрэгтэй” гэж бодсоны үндсэн дээр Энэтхэг, Хятад, Балба, Ли, Хачэ / Кашмир/, Монгол, Түгү, долбо, Дом зэрэг орноос эрдэмтэд урин чуулган хийж байсан

тухай бичсэн байдаг [20]. Мөн <<Төвөд хэлнээс монгол хэлэнд хөрвүүлэн буулгасан уламжлалт орчуулгын зохиолыг судлах ажил манай улсад 20-р зууны дунд үеэс эхэлсэн байна. Үүнд академич Ц.Дамдинсүрэн ихээхэн хичээл зүтгэл гаргасан бөгөөд тэрээр төвөд хэлнээс монгол хэлнээ орчуулсан уламжлалт орчуулгын зохиолын дээжийг түүвэрлэн эмхэтгэж, судалгааны өгүүллийн хамт 1959 онд хэвлүүлсэн нь уламжлалт судалгааны ажлын эхлэл болсон>> [12] хэмээснээс үзэхэд төвөд хэлнээс ном судар орчуулах ажлыг чухалд үзэж байсан нь харагдаж байна.

Дүгнэлт

Хамба Шивацо нь МЭ-725 онд Энэтхэгт төрж төвөдөд бурхны шашныг дэлгэрүүлэхэд оролцсон нэрт гүн ухаантан бөгөөд Төв үзлийн номлол, бясалгалын чиглэлээр номлож, бүтээлээ туурвиж, олон бүтээлийг санскрит хэлнээс төвөд хэлэнд орчуулах ажилд оролцож байжээ. Тэрээр бясалгал, төв үзлийн бүтээлүүдээрээ орчин үеийн урьдчилан сэргийлэх анагаах ухаанд хэрэглэгдэж байгаа иог, бясалгалын эхлэлийг тавьсан ба эмийн лавлах бичиг бичиж дараа дараагийн эрдэмтэн судлаачдад гарын авалга болгожээ. Түүний энэ бүтээл нь хугацааны хувьд “Анагаах ухааны дөрвөн үндэс” хэмээх шүнгийн номны дараа бичигдсэн, дан ургамалын гаралтай 200 гаран эмүүдийг маш нарийн тайлбарын хамт багтаасан бөгөөд монгол эрдэмтэд уг бүтээлээс суралцаж, өөрсдийн бүтээлдээ ашигласан байх магадлалтай ач холбогдол бүхий сурвалж бичиг юм.

Түлхүүр үг: дарь эх, Тисрондэзан хаан, төв үзэл, хамба, ургамалын эм

Ном зүй

1. Сукумар Дасс. Буддхын шашны түүх. Улаанбаатар. 2016 он. Бэмби сан хэвлэлийн газар. Орчуулсан Гэндэндарам Ж., х.7
2. Шоннупэл Гой-лоцава. Синья летопись. Санкт Петербург. 2001 года. Издательство Евразия, с.8
3. Дамдинсүрэн Ц, Лувсандэндэв А. Орос монгол толь. 1983 он. УХГ. х.12-840
4. 希瓦错. 度母本草-藏汉对照. 2016年.青海人民出版社有随责任公司. х.1,2,8
5. Лодой Г. Шинжлэх ухааны судалгааны аргазүй. Улаанбаатар. 2005 он. МУИС, х.47-57

6. Тойн Жамбалдорж. Монгол эмийг зөв таних толь. Улаанхад. 2015 он. Орчуулсан Гэндэнжалцан В., х.9-31,
7. Данзанпунцаг, “Эмийн хир үгүй болор эрхи”,
8. Сүмбэ хамба Ишбалжир, “Цагаан болор толь”,
9. Галсан С. Төвөд монгол эмнэлгийн толь. Хөх хот. 2008 он. ӨМАХХ, х.5, 14, 49. 120, 141, 205
10. Тэрбиш Л. Төвөд монгол иж бүрэн толь. Улаанбаатар. 2020 он. “Адмон” ХК, х. 2-1685
11. МУШУА, Философи, социологийн хүрээлэн. Соёл иргэншил, гүн ухаан хөгжил. Улаанбаатар. 1998 он. “Бит сервис”, х.7
12. Гансүх С. Судар орчуулах эрдэм. Улаанбаатар. 2013 он. “Мөнхийн үсэг” ХХК, х.6, 13
13. Буддын соёл судалгааны төв. Буддын шашны соёлын тайлбар толь. Улаанбаатар 2000 он. “Өнгөт хэвлэл” ХК, х. 5
14. Болд Ш. Гүн ухаан, онол, биемахбод судлал. Улаанбаатар. 2012 он. “Мөнхийн үсэг” ХК, х.58-59
15. Болд.Ш. Монголын Анагаах Ухааны Түүх. Улаанбаатар. 2011он. “Admon printing” ХК, х.170-175
16. Буянт Б., Зууннаст Ж. Монгол анагаах ухааны мэргэдийн намтар бүтээлийн судлал. Хөх хот. 2008 он. ӨМАХХ, х.2-4
17. Болд Ш. Төвөд хэл сурах бичиг. Улаанбаатар. 2011 он. “Мөнхийн үсэг” ХХК, х.6
18. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх 4-р боть. Улаанбаатар. 2013 он. “Admon printing” ХК, х.49
19. Бира Ш. Монголын түүх соёл, түүх бичлэгийн судалгаа 3-р боть. Улаанбаатар. 2001. он УХГ, х.388
20. Болд.Ш. Монголын анагаах ухааны түүх 2-р боть. Улаанбаатар. 2013 он. “Admon printing” ХК, х.161

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор, профессор
Ч.Чимэдрагчаа*